



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 256

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй  
дуудлагын худалдаагаар худалдах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Зам, тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 31,673,400.00 (гучин нэгэн сая зургаан зуун далан гурван мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "Зам, тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Р.Будад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу төрийн өмчит үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д оруулан бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001913



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Р.Б. дугаар тогтоолын хавсралт

**"Зам, тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин**

д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	УАЗ-22069 маркийн, 16-23 УБГ улсын дугаартай, Арлын дугаар -60479033, Хөдөлгүүрийн дугаар - 60101374	2006/2006	218920	16,169,000.00	16,169,000.00	0.00		1,500,000.00
2	Мицубиши Страда маркийн, 04-52 УБА улсын дугаартай бага оврын ачааны автомашин, Арлын дугаар - К340002711	1992/2005	135819	15,504,400.00	15,504,400.00	0.00		2,000,000.00
				<b>31,673,400.00</b>	<b>31,673,400.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>3,500,000.00</b>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>			<b>31,673,400.00 (гучин нэгэн сая зургаан зуун далан гурван мянга дөрвөн зуу)</b>	<b>31,673,400.00 (гучин нэгэн сая зургаан зуун далан гурван мянга дөрвөн зуу)</b>			<b>3,500,000.00 (гурван сая таван зуун мянган)</b>